

## 17. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ



## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

---

17-1. Санхүүгийн эрсдэл .....	249
17-2. Эрсдэлийг удирдах .....	249
17-3. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх хөрөнгө оруулалт .....	250

## 17-1. Санхүүгийн эрсдэл

Аж ахуй нь үндсэн үйл ажиллагааны орлогоороо зардлаа санхүүжүүлж чадахгүй болох процессыг санхүүгийн эрсдэл гэнэ.

### Санхүүгийн эрсдэл хэрхэн бий болдог вэ?

Танай бизнесийн үйл ажиллагаа хэвийн бус үргэлжлэх үед санхүүгийн эрсдэл бий болдог. Тухайлбал:

- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар муудах
- ✓ Стандартад нийцсэн, хэрэглэгчдийн таашаалд нийцэх зөгийн балыг бэлтгэж чадахгүй байх
- ✓ Маркетингийн оновчгүй бодлого явуулах
- ✓ Зах зээл буюу хэрэглэгчдийн тухай судалгаа, мэдээлэлд үндэслэсэн төлөвлөгөө байхгүй байх
- ✓ Гэнэтийн болзошгүй эрсдэлүүд бий болох
- ✓ Зөгийн суурьт халдварт өвчин дэгдэх, үер ус, гал түймэрт өртөх, өвөлжөөнд олноор хорогдох, баавгайд сүйтгүүлэх г.м.
- ✓ Үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод хяналт алдагдах
- ✓ Үйл ажиллагаа болон орлого, зарлагын төлөвлөгөөг муу хийсэн болон эргэж хянахгүй байх
- ✓ Буруу зүйлд хөрөнгө оруулалт хийх
- ✓ Ажиллах хүч болон бусад нөөц бололцооноос хэтэрсэн тоогоор зөгийн бүл худалдан авах, үүний тулд өндөр хүүтэй зээл авах, бусдын зар сурталчилгаанд автан ашиглах боломжгүй, ашигласан ч үр ашиггүй багаж тоног төхөөрөмжийг худалдан авах (тухайлбал зөгийн хор цуглуулах, эх зөгийг зохиомлоор хээлтүүлэх багаж г.м.)
- ✓ Эдийн засгийн хямрал /инфляци/-д өртөх
- ✓ Нийт үйлчлүүлэгчдийн худалдан авах чадвар муу болсон үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө байхгүй байх

## 17-2. Эрсдэлийг удирдах

Байгууллагын санхүүгийн тайлангаас санхүүгийн эрсдэлийг харж болно. Тухайлбал:

- Нийт хөрөнгөнд эзэлж байгаа өр төлбөрийн хувь нэмэгдэх
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал нь борлуулалтын орлогоосоо давах үед алдагдал бий болдог. Алдагдалтай ажиллаж байвал санхүүгийн эрсдэлд орсоны дохио.

Орлого < Зардал

- Мөнгөний үлдэгдэл илт буурах

Иймд боломжтой бол санхүүгийн төлөвлөгөө, бүртгэлээ сар, улирлаар хийж ойр ойрхон эргэн хянаж байх нь чухал юм. Эрсдэлийг эрт мэдэрсэн тохиолдолд хүндрэлээс гарах гарц олдоно. Хожуу мэдрэх тусам хүндрэл ихсэх болно.

### **Эрсдэлийг хэрхэн удирдах вэ?**

Санхүүгийн эрсдэлийг удирдах доорх арга замууд байж болно. Үүнд:

- Эрсдэлээс сэргийлэх
- Эрсдэлийг бууруулах
- Эрсдэлийг шилжүүлэх

### **1. Эрсдэлээс сэргийлэх:**

Эрсдэлтэй алхам хийхгүй байх нь эрсдэлээс сэргийлэх арга зам юм. Жишээ нь:

- Эрсдэлтэй зүйлд (судлаагүй, эргэлзээтэй) хөрөнгө оруулалт хийхгүй байх
- Ажиллагсдын аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Татварын болон хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай зэрэг хуулийг зөрчихгүй байх

### **2. Эрсдэлийг бууруулах:**

Урьдчилан сэргийлэх боломжгүй эрсдэл тохиолдох (балт ургамлын нөөц хэт багасах г.м.) үед эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй. Борлуулалт огцом багасах нэгэнт тодорхой болсон ийм нөхцөлд зардлын хэмнэлт бий болгож алдагдалтай ажиллах эрсдэлийг бууруулах хэрэгтэй. Үүнд: Огор нүүдлийг багасгах, цагийн ажилтныг цөөрүүлэх, тухайн улиралд төлөвлөсөн худалдан авалтаа эрэмбэлэн шаардлагагүйг нь цуцлах арга хэмжээ авч болох юм.

### **3. Эрсдэлийг шилжүүлэх:**

Зөгийн аж ахуйн бизнес эрхлэх нь алдагдалтай байна, энэ нь урт удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна гэж үзвэл бизнесээ зогсоох шаардлагатай. Та хангалттай бэлэн болсон үедээ дахин эхлэх талаар бодож үзээрэй. Үүний тулд танд зөгий маллах туршлага ихээр хуримтлуулах, санхүүгийн мэдлэгээ сайжруулах зэрэгт анхаарлаа хандуулаарай.

Шинээр зөгийн аж ахуй эрхлэх үед санхүүгийн эрсдэлд орохгүйн тулд анхаарах зүйл:

1. Бусад зөгийн аж ахуйн санхүүгийн үйл ажиллагаатай танилцах (асуух, ярилцах), судлах
2. Цөөн тооны зөгийн бүлтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлэх
3. Ирээдүйн төлөвлөгөө (хэдэн бүл зөгий маллаж чадах ба тэдгээрээс хэдий хэмжээний бал бэлтгэх, түүний тулд хэзээ юунд хөрөнгө оруулах шаардлагатай эсэх) боловсруулах.

## **17-3. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх хөрөнгө оруулалт**

Хөрөнгө оруулалт гэдэг нь үр өгөөж хүртэнэ гэж итгэсний үндсэн дээр мөнгөө ирээдүйд ашиг, орлого авчрах зүйлд зарцуулахыг хэлнэ.

Зөгийн аж ахуйн хувьд тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын байр, тээврийн хэрэгсэл, өвөлжөөний байр, зөгийн бүл худалдан авч хөрөнгө

оруулалт хийх шаардлага үүсдэг. Гэвч эдгээрийг нэг удаагийн хөрөнгө оруулалтаар худалдан авах шаардлагагүй ба эдгээрийг хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэх, хөрөнгө оруулах өөр арга замуудыг ашиглах боломжтой байдаг. Тухайлбал, та тодорхой хугацаанд зөгийн аж ахуй эрхэлж байгаа бол зөгийн бүл худалдан авахад хөрөнгө оруулалт хийх нь төдийлөн оновчтой биш бөгөөд үүний оронд зөгийн бүлээ өсгөн нэмэгдүүлэх арга технологид суралцах нь илүү ач холбогдолтой юм.

Мөн бусадтай хамтарч өвөлжөө барих, ажлын байр (бал савлах өрөө, агуулах) хөрөнгө оруулалт хийх нь зардлаа хэмнэх, үр ашиг өндөртэй байхад чиглэсэн чухал арга болдог.

Хөрөнгө оруулалтын нэг хэлбэр нь ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч талын дэмжлэгийг авах явдал юм. Үүний тулд хүсэлт гаргах буюу төсөл бичих шаардлага үүсдэг.

